

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2014 оны 05 сарын 27-ний өдрийн хурлын
24-р тогтоолын 1 дүгээр хавсралт



ХӨНДЛӨНГИЙН АУДИТ ТОМИЛОХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ


- 1.1. Энэхүү Хөндлөнгийн аудит томилох журам /цаашид "Журам" гэх/-ын зорилго нь "Говь" ХК /цаашид "Компани" гэх/-ийн санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргийг гүйцэтгэх хараат бус, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-өөс сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү Журмыг Аудитын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 сарын 7-ны өдрийн 162 тоот тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодекс, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн боловсруулав.
- 1.3. Хөндлөнгийн аудитор нь сонирхлын зөрчлөөс ангид, бие даасан, хараат бус, мэргэжлийн өндөр ур чадвартай байна.

ХОЁР. ХАРААТ БУС АУДИТЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан явуулна.
- 2.2. Гүйцэтгэгчээр аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хараат бус аудитын хуулийн этгээдийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо шалгаруулан дүгнэлт гаргаж, санал боловсруулах бөгөөд ТУЗ-ийн хурлаар сонгож томилно.
- 2.3. Хараат бус аудитыг сонгон шалгаруулах үйл явцад ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
 - Аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хараат бус аудитын хуулийн этгээдүүдийн жагсаалт гарган, шалгуурын дагуу дүгнэлт хийн ТУЗ-д танилцуулах;
 - Хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага болон бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэх;
 - Хараат бус аудиторын хараат бус байдал болон бусад шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийх;
 - Хараат бус аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайланд аудит хийлгэх ерөнхий мэдээллийг багцалж, хараат бус аудитын байгууллагуудын үнэлгээний үр дүнг нэгтгэн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх.

ГУРАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД БАРИМТЛАХ ШАЛГУУР

- 3.1. Хөндлөнгийн аудитораар томилох хуулийн этгээд нь доорх шалгуурыг хангасан байна. Үүнд:
 - 3.1.1. Аудит, үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан байх;



- 3.1.2. СЗХ-ны 2013 оны 452 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай” журмын тавигдах шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсэн хуулийн этгээд байх, аудиторуд нь тус хуулийн этгээдийн орон тооны ажилтан байх;
- 3.1.3. Говь ХК-тай Компанийн тухай хуулийн 94.13-т заасан “хараат бус аудиторроор сонгон ажиллуулахыг хориглох” аливаа хамааралгүй байх;
- 3.1.4. СЗХ-ны 2012 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан “Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргахад мөрдөгдөх заавар”-ын дагуу дүгнэлтээ гаргах;
- 3.1.5. Компанийн тухай хуулийн 94.16-д заасан мэдээллийг бүрэн агуулсан байх;
- 3.1.6. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцоолол, санхүүгийн тайлагналын талаар гаргасан дүгнэлтийнхээ хүрээнд татварыг шалгалт орсон үед үнэ төлбөргүй тайлбар өгөх;
- 3.1.7. Тайлангийн жилд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах.
- 3.2. Хөндлөнгийн аудитор нь олон улсын аудитын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

